



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136. Утас: 7012-8801,
Факс: (976) 32-06-33, E-mail: admin@hdc.gov.mn,
<http://www.chd.mohs.mn>

2022.11.01 № 926

танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗАР БОЛОН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв эмнэлгүүдээс 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна. Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 6 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

142204000682

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

/2022 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 420 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа ба дийлэнх буюу 93% /392/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт1/.

Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо	
		4-6 хоног	7-с дээш хоног
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	62
2	Толгой, хүзүүний мэс засал	1	58
3	Туяа	3	50
4	Хими	2	48
	Ерөнхий мэс засал	9	40
4	Элэг, цес, нойр булчирхайн мэс засал	10	37
	Хөхний төв	-	31
	Гепатологи	-	25
5	Ангиографи	-	23
8	Зүрх судас	1	17
11	Цээжний хөндийн мэс засал	2	-
12	Хөнгөвчлөх	-	1
	Нийт	29	392

Эмэгтэйчүүдийн мэс заслын амбулаториор 62, Толгой, хүзүүний мэс заслын үзлэгийн кабинетэд 58 үйлчлүүлэгч 7 ба түүнээс дээш хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоног нийт 139 үйлчлүүлэгч хүлээж байгаа ба КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 41, эхо оношилгоо хийлгэхээр 32, ходоод дурандуулахаар 31 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоногоор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарч байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Нийт 508 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байна /Хүснэгт 2/.

Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо			
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	Нийт
1	Өдрийн хими	17	78	121	216
2	Хими	11	68	113	192
3	Ангиографи	3	8	14	25
4	Хөнгөвчлөх	1	7	8	16
5	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	1	4	10	15
6	Толгой, хүзүүний мэс засал	9		2	11
7	Туяа	1	7	3	11
8	Эмэгтэйчүүдийн мэс засал		5	3	8
9	Ерөнхий мэс засал	1	1	3	5
10	Дуран		3	1	4
11	Цээжний хөндийн мэс засал		3		3
12	Хөхний төв		1	1	2
	Нийт	44	185	279	508

Тус эмнэлэгт өдрийн хими эмчилгээ хийлгэхээр нийт 216 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж буй үзүүлэлттэй байгаа боловч хавдартай үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлот хими эмчилгээ хийдэг нь хүлээгдэлтэй харагдахад нөлөөлдөг болно. Хими эмчилгээний тасагт хэвтэхээр 192 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн 94% нь 7-с дээш хоног ор хүлээж байгаа нь тус эмнэлгийн хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн тайлангаас харахад амбулаторийн тусламж, үйлчилгээ 2022 оны 10 сард хүлээгдэл багатай байна. Бөөрний эмчид үзүүлэхээр 1 үйлчлүүлэгч 4-6 хоног, Булчирхайн эмчид үзүүлэхээр 2 үйлчлүүлэгч 4-6 хоног, Хэрх үе судлалын эмчид үзүүлэхээр 2 үйлчлүүлэгч 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Оношилгооны хувьд тус эмнэлгийн MRI-ийн оношилгооны хүлээгдэл маш их байгаа ба 285 үйлчлүүлэгч 15-с дээш хоног хүлээж байна. 1 ширхэг аппаратад өдөрт 16-18 хүн оношлогоонд хамрагддаг ба эдгээрийн 15 үйлчлүүлэгч нь амбулатороос шинжилгээнд илгээсэн үйлчлүүлэгчид байна. MRI шинжилгээний хувьд энэ оныг дуустал эмчлүүлэгчдийг хүлээлгийн захиалганд бүртгэсэн бөгөөд цааш хүлээлгэнд бүртгэхгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1134 үйлчлүүлэгч ор хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй 5 тасгийн мэдээллийг Хүснэгт 3-д харуулав.

Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Нүдний тасаг	3-6 хоног	13
		7-14 хоног	40

		15-30 хоног	94
		1 сараас дээш	250
	Нийт		397
2	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	11
		7-14 хоног	36
		15-30 хоног	16
		1 сараас дээш	307
	Нийт		370
3	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг	3-6 хоног	4
		7-14 хоног	23
		15-30 хоног	61
		1 сараас дээш	126
	Нийт		214
4	Мэс заслын тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	19
		15-30 хоног	19
		Нийт	58
5	Бөөрний мэс заслын тасаг	3-6 хоног	18
		7-14хоног	16
		Нийт	34

Нүдний тасагт хэвтэхээр нийт 397 үйлчлүүлэгч ор хүлээж байгаагийн талаас илүү буюу 63% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Чих хамар хоолойн тасгийн 370 үйлчлүүлэгчийн орны хүлээгдлийн дийлэнх буюу 83% нь удаан хугацаанд, 1 сараас дээш хугацаанд ор хүлээжээ. Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэхээр 214 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 126 нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.

3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Нийт 94 үйлчлүүлэгч амбулаторийн 6 төрлийн кабинетийн эмчид үзүүлэхээр хүлээж байна. Үүнээс хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэдрэл судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	3 хоног	2
		4-6 хоног	0
		7-с дээш хоног	37
		Нийт	39
2	Мэдрэл судлал	3 хоног	2
		7-с дээш хоног	18
		Нийт	20
3	Мэс засал судлал	3 хоног	2
		7-с дээш хоног	12
		Нийт	14
4	Бөөр судлал	3 хоног	2
		4-6 хоног	2

		7-с дээш хоног	8
	Нийт		12
5	Эмэгтэйчүүд судлал	3 хоног	2
		7-с дээш хоног	4
	Нийт		6
6	Нүд судлал	4-6 хоног	1
		7-с дээш хоног	2
	Нийт		3
	БҮГД		94

Эхо оношилгоо хийлгэхээр хамгийн их буюу нийт 28 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 25 нь 15-с дээш хоногоор хүлээгдэлтэй байна. Мөн рентген зураг авахуулахаар 13 үйлчлүүлэгч, MRI/CT хийлгэхээр 6 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлэгт биохимийн шинжилгээ хийлгэхээр 55 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн 30 нь 3-6 хоног, 11 нь 7-14 хоног, 14 үйлчлүүлэгч 15 ба түүнээс дээш хоног хүлээж байна. Бусад шинжилгээн дээр хүлээгдэлгүй. Орны хүлээгдлийн хувьд авч үзвэл, тус эмнэлгийн Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй байна. Уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 127 үйлчлүүлэгч ор хүлээж байна./Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэс засал судлал	3-6 хоног	15
		7-14 хоног	58
		15-30 хоног	54
	Нийт		127
2	Чих, хамар, хоолой судлал	3-6 хоног	15
		7-14 хоног	12
		15-30 хоног	27
	1 сараас дээш	18	
Нийт		72	
3	Уламжлалт анагаах ухааны эмчилгээний тасаг	3-6 хоног	10
		7-14 хоног	7
		15-30 хоног	14
	1 сараас дээш	7	
Нийт		38	
4	Эмэгтэйчүүд судлалын тасаг	3-6 хоног	7
		7-14 хоног	12
		15-30 хоног	8
	1 сараас дээш	10	
Нийт		37	
5	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	8
		7-14 хоног	5
		15-30 хоног	7
Нийт		20	
6	Зүрх судас судлал	3-6 хоног	5
		7-14 хоног	7
Нийт		12	

7	Мэдрэлийн мэс засал судлал	3-6 хоног	4
		7-14 хоног	3
		15-30 хоног	5
	Нийт		12
8	Бөөрний мэс засал судлал	3-6 хоног	2
		7-14 хоног	8
		15-30 хоног	2
	Нийт		12
9	Мэдрэл судлал	3-6 хоног	3
		7-14 хоног	2
	Нийт		5
10	Уушиг судлал	3-6 хоног	2
	БҮГД		337

Мэс засал хийлгэхээр 127 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн ихэнх буюу 88% нь 7-30 хоног хүлээж байна.

4. Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн зөвхөн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэлтэй байгаа ба нийт 808 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байна. Чих хамар хоолойн тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 448 үйлчлүүлэгч, зүрхний мэс засал, судасны мэс заслын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 295 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн 92%-ийг эзэлж байна.

Хүснэгт 6. ШУГТЭ-ийн хамгийн их орны хүлээгдэлтэй 2 тасгийн мэдээ /2022 оны 10 сарын 28-ны өдрийн байдлаар/

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	3-с дээш хоногоор ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих хамар хоолойн тасаг	3-6 хоног	25
		7-14хоног	55
		15-30 хоног	160
		1 сараас дээш	208
		Нийт	448
2	Зүрхний мэс засал, судасны мэс заслын тасаг	3-6 хоног	45
		7-14хоног	60
		15-30 хоног	100
		1 сараас дээш	90
		Нийт	295
	БҮГД		808 /92%/

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэг, оношилгоо, лабораторийн тасгууд хүлээгдэлгүй байна.

5. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлэг нь тусламж, үйлчилгээний хүлээгдэл багатай ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар амбулаторийн тусламж, үйлчилгээ

авахаар нийт 16 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байна. MRI шинжилгээ хийлгэхээр 130 үйлчлүүлэгч, КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 46 үйлчлүүлэгч тус тус 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд хамгийн их хүлээгдэлтэй тасагт Түлэнхий нөхөн сэргээх мэс заслын тасаг хамаарч байгаа ба тус тасагт хэвтэн эмчлүүлэхээр 31 үйлчлүүлэгч х 7-с дээш хоног хүлээж байна. Мөн Гар сарвуу, нөхөн сэргээх бичил мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 18 үйлчлүүлэгч, үүний 8 нь 3-6 хоног, 10 нь 7-14 хоног тус тус хүлээж байна.

6. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус төвийн амбулаторийн үзлэг, оношилгоо, лабораторийн тасгууд хүлээгдэлгүй ба Арьс харшлын тасагт хэвтүүлэн эмчлүүлэхээр 10, Мөөгөнцрийн тасагт хэвтэхээр 2 үйлчлүүлэгч тус тус 3-6 хоног ор хүлээж байна.

7. Геронтологийн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвүүд нь хүлээгдэлгүй ажиллаж байна.
8. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхэд, нярайн төв-2, Амаржих газрууд болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.